



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 09 өдөр

Дугаар А/646

Ховд

Жуух бичгээр шагнах тухай

Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Монгол улсын Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн "Е", аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.8, 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Монголын багш нарын 53 дахь баярын өдрийг тохиолдуулан Боловсролын салбарт хамт олноо манлайлан олон жил үр бүтээлтэй ажиллаж буй Зэрэг сумын Ерөнхий боловсролын сургуулийн Монгол хэлний багш Н.Нарантуяа Мянгад сумын Ерөнхий боловсролын сургуулийн эмч Н.Мөнхцэцэг, Технологийн багш В.Мягмардорж, Цэцэг сумын Ерөнхий боловсролын сургуулийн Биологийн багш Ж.Жука, Шугам зураг, технологийн багш Т.Баатар, Чандмань сумын Ерөнхий боловсролын сургуулийн Газар зүйн багш Л.Байгалмаа, Бага ангийн багш Д.Орломсүрэн, Л.Удвал, Эрдэнэбүрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн Бага ангийн багш Ч.Дуламсүрэн, Англи хэлний багш Н.Мөнхцэцэг нарыг аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр шагнасугай.

2.Аймгийн Засаг даргын жуух бичгээр шагнагдсан Н.Нарантуяа Н.Мөнхцэцэг, В.Мягмардорж, Ж.Жука, Т.Баатар, Л.Байгалмаа, Д.Орломсүрэн, Л.Удвал, Ч.Дуламсүрэн, Н.Мөнхцэцэг нарт 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг дээрх сумдын Ерөнхий боловсролын сургуулийн захирлуудад зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/646 Ch  
02 03206